

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

**Оюу толгойн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө**

2015 оны 12 дугаар сарын 2

Оюу толгой төслийн анхны Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг (БОЯБҮАТ) Оюу толгой компани болон Төслийн санхүүжүүлэгчид Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд 2012 оны 8 дугаар сард баталж, олон нийтэд танилцуулсан. Менежментийг нөхцөл байдалд тохиромжтой байлгах зорилгын хүрээнд уг төлөвлөгөөнд тогтмол шинэчлэл хийж Биологийн олон янз байдлын удирдлагын хөтөлбөрийн үйл явцыг тусгаж байх шаардлагатай. Холбогдох санхүүгийн бичиг баримтад тусгагдсан бөгөөд шаардагдсан тохиролцооны дагуу Оюу толгой болон санхүүжүүлэгч байгууллага тохиролцсоны үндсэн дээр БОЯБҮАТ-г хянан засварлаж болно. Энэхүү 2015 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хамгийн сүүлийн хувилбарт 2012 оны БОЯБҮАТ-д тусгагдаж, бүрэн дууссан, мөн өөрчилсөн болон шинээр нэмсэн арга хэмжээнүүд багтсан. Уг төлөвлөгөөг жил бүр олон нийтэд түгээнэ. БОЯБҮАТ-г хэрэгжүүлэх нь Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд (БОНҮАТ) тусгасан шаардлага юм. БОНҮАТ нь мөн олон нийтэд түгээгдсэн бичиг баримт болно.

№#	СЭДЭВ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛБАР	ХЭРЭГЖИЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА
<b>УДИРДЛАГА БА НӨӨЦ</b>				
1	Шаардлагатай нөөцөөр хангах	Оюу толгой компани нь уурхайн талбай дахь нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа, мөн уурхайн талбайн гадуурх удирдлага болон биологийн олон янз байдлын мониторингийн хөтөлбөрүүд нь урт хугацаанд ОУВС-ийн 6 дугаар гүйцэтгэлийн стандарт (PS6), ЕСБХБ-ийн гүйцэтгэлийн шаардлага (PR6), БОННҮ-ний үүрэг амлалтуудыг хангах, мөн биологийн олон янз байдлын хувьд цэвэр эерэг үр ашиг авчрахад шаардлагатай нөөц бололцоо, санхүүжилтыг бүрдүүлнэ.	Хэрэгжиж буй	Хэрэгжиж буй
2	Биологийн олон янз байдлын шинжлэх ухаан болон хамгааллын байгууллага (ууд)-тай урт хугацаанд хамтран ажиллах	Оюу толгой компани нь олон улсын нэр хүндтэй, баталгаажсан байгууллагуудтай албан ёсоор хамтарч, Оюу толгойн биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөг боловсруулах, тохиромжтой бол хэрэгжүүлэх ба дараах ажлуудыг төлөвлөгөөнд тусгана: <ul style="list-style-type: none"> <li>• Биологийн олон янз байдлын урт хугацааны мониторинг ба үнэлгээ,</li> <li>• Тохиромжтой бол Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний тодорхой хэсгийг боловсруулж, хэрэгжүүлж, мөн удирдан зохицуулах,</li> <li>• Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөг боловсруулах болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> </ul> <p>Хамтын ажиллагааны хүрээнд ОТ-д мэдээлсний үндсэн дээр</p>	(i) Хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулсан  (ii) Хамтран ажиллах гэрээний төслийг Санхүүжүүлэгч зөвшөөрсөн  (iii) Хүлээн авсан саналуудыг Санхүүжүүлэгчдэд танилцуулах	(i) Дууссан  (ii) Дууссан  (iii) Дууссан  (iv) Хэрэгжиж

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

		Санхүүжүүлэгчид зөвлөмж, санал хүсэх зорилгоор тухайн мэргэжлийн байгууллагатай бие даан харилцах боломжтой байхаар зохицуулна.  ОТ хамтран ажиллах байгууллагатай хийсэн гэрээ болон гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах бол эхлээд Санхүүжүүлэгчидтэй зөвшилцөнө.	(iv) Хамтран ажиллах  (v) Хамтран ажиллах гэрээ болон байгууллагад өөрчлөлт оруулах тохиолдолд Санхүүжүүлэгчидтэй зөвшилцөнө	буй  (v) Хэрэгжиж буй
3	Мэргэжлийн ур чадвар	Оюу толгойн биологийн олон янз байдлын багт биологийн олон янз байдлын үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, ур чадвар, манлайлал үзүүлэх олон улсын тэргүүн туршлага эзэмшсэн, Монгол улсад байрлаж буй хувь хүн эсвэл бүлэг ахлах түвшний мэргэжилтнүүдийг Оюу толгойд бүтэн цагаар ажиллуулна. Тухайн ахлах мэргэжилтэн(үүд) хувь хүн тус бүр, эсвэл багаараа дараах чиглэлээр туршлага эзэмшсэн байна: биологийн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, биологийн олон янз байдлын мониторинг болон ижил түвшний хамрах хүрээ, нөхцөл байдал бүхий биологийн олон янз байдлын хөтөлбөрийн удирдлага.  Ахлах мэргэжилтнүүдийн нэг (эсвэл ахлах мэргэжилтэн) нь биологийн олон янз байдлын хөтөлбөрийг удирдан зохицуулах албан тушаалд (Хариуцсан мэргэжилтэн) байх ба Оюу толгойн биологийн олон янз байдлын үндэсний мэргэжилтнүүд төслийн биологийн олон янз байдлын үүрэг амлалтуудыг хэрэгжүүлж, зохицуулах ур чадварыг бүрэн эзэмших хүртэлх шаардлагатай хугацаанд уг албан тушаалд мэргэжилтэн ажиллуулна.  Ур чадвар хөгжүүлэх үйл ажиллагааг Төслийн олон улсын биологийн олон янз байдлын байгууллагаас (2 дугаартай хэсэгт тодорхойлсноор) зөвлөмж өгч, мөн Санхүүжүүлэгчидтэй зөвшилцөн жил бүр хянан шалгана.	(i) Ажилд авах үйл ажиллагааг эхлүүлэх  (ii) Мэргэжилтэн(үүд)-ийн товч намтрыг Санхүүжүүлэгчдэд өгнө  (iii) Хариуцсан мэргэжилтнийг Монголд байршуулна (iv) Санхүүжүүлэгчидтэй зөвшилцөж, жил тутмын хянах үйл ажиллагааг явуулна (v) Ур чадварыг хөгжүүлэх шалгууруудыг боловсруулж, Санхүүжүүлэгчидтэй харилцан тохиролцоно	(i) 2016 оны 1 дүгээр улирал (ii) 2016 оны 2 дугаар улирал (iii) 2016 оны 3 дугаар улирал  (iv) Жил бүр  (v) 2016 оны 4 дүгээр улирал
4	Бие даасан шинжлэх ухааны зөвлөх байгууллага	Оюу толгой компани нь удирдамжийн дагуу бие даасан шинжлэх ухааны зөвлөлөөс ОТ-Гашуун сухайтын замын нөлөөлөл бууруулах үйл ажиллагаатай холбоотой техникийн асуултууд, мөн Оюу толгой болон Санхүүжүүлэгчид харилцсан тохиролцсоны дагуу бусад асуудлуудаар хамтран ажиллана (Зөвлөл). Зөвлөлийн гишүүдийн тоо гурваас	(i) Удирдамж болон эхний даалгаврыг эцэслэж, ОТ болон Санхүүжүүлэгчид харилцан тохирно  (ii) ОТ болон Санхүүжүүлэгчид	(i) 2016 оны 2 дугаар улирал  (ii) 2016 оны 4

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

		<p>хэтрэхгүй.</p> <p>Зөвлөлийн тодорхой даалгавруудыг нэг бүрчлэн ажлын хамрах хүрээгээр тодорхойлно. Дээр дурьдсаны дагуу Зөвлөлийн эхний зорилго нь ОТ – Гашуун сухайтын замын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой техникийн асуултуудад саналаа өгөх байна.</p> <p>Шаардлагатай бөгөөд тохиролцсон ирээдүйн даалгаврын дагуу Зөвлөлөөс Гүйцэтгэлийн стандарт 6 болон Гүйцэтгэлийн шаардлага 6-д нийцүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээний талаар шинжлэх ухааны бие даасан зөвлөмжийг Санхүүжүүлэгчдэд болон ОТ-д өгнө.</p> <p>Зөвлөлийн илрүүлсэн зүйлсийг олон нийтэд танилцуулна.</p>	<p>харилцан тохиролцож, эхний даалгаврын зөвлөлд орох гишүүдтэй харилцана</p> <p>(iii) ОТ болон Санхүүжүүлэгчид тохирсны дагуу Зөвлөлийн замын нөлөөлөл бууруулах тайланг танилцуулна (зүйл 13).</p> <p>(iv) Зөвлөлийн замын нөлөөллийн стратегийн хяналтаас гарсан, ОТ болон Санхүүжүүлэгчид зөвшөөрсөн арга хэмжээг ОТ-н удирдлагын төлөвлөгөөнүүдэд тусгана</p> <p>(v) Цаашид даалгавар, ажлын хамрах хүрээ, зөвлөлийн гишүүд, тайлангийн нийтлэл болон арга хэмжээг ОТ болон Санхүүжүүлэгчид тохиролцоно.</p>	<p>дүгээр улирал</p> <p>(iii) 2017 оны 3 дугаар улирал</p> <p>(iv) 2017 оны 3 дугаар улирал</p> <p>(v) Шаардлагатай хугацаанд</p>
<b>МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭ</b>				
5	Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө	<p>Гүйцэтгэлийн стандарт 6-ийн аравдугаар мөр болон Гүйцэтгэлийн шаардлага 6-ийн наймдугаар мөрийн дагуу урт хугацаанд төслийн нийцлийг хангахуйц ховор уугуул төрөл зүйлүүдэд зориулсан Биологийн олон янз байдлын үнэлгээ, мониторингийн хөтөлбөрийг (БОЯБҮМХ) Оюу толгой компани боловсруулна. БОЯБҮМХ-д ОТ-н оролцогч талуудтай харилцах харилцаа болон Гүйцэтгэлийн стандарт 6-ийн есдүгээр мөр, Гүйцэтгэлийн шаардлага 6-ийн зургадугаар мөрт төсөл нийцэж буйг тодорхойлоход хангалттай байхаар биологийн олон янз байдлын бусад чухал төрөл зүйлүүдийг тусгана. Ховор уугуул төрөл зүйл болон чухал биологийн олон янз байдлын зүйлсийн хувьд урт хугацааны нийцэл болон статистикийн үүднээс ач холбогдолтой байхаар холбогдох хэмжих үзүүлэлтүүдийг мониторингийн төлөвлөгөөнд тусгана.</p>	<p>(i) БОЯБҮМХ-ний төслийг Санхүүжүүлэгчдэд хянуулахаар өгнө.</p> <p>(ii) Эцсийн БОЯБҮМХ-г өгнө</p> <p>(iii) БОЯБҮМХ-н харилцан тохирсон хувийг нийтэлнэ</p> <p>(iv) БОЯБҮМХ-г хэрэгжүүлж, үр дүнг жил бүр нийтэлнэ (Санхүүжүүлэгчидтэй тохирсон байдлаар)</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) 2015 оны 4 дүгээр улирал</p> <p>(iii) 2016 оны 1 дүгээр улирал</p> <p>(iv) 2016 оноос эхлэн цаашид</p>

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

6	Экосистемийн үйлчилгээний мониторинг	Оюу толгой компани Экосистемийн үйлчилгээний ажлын хэсгээр дамжуулан нэн чухал экосистемийн үйлчилгээнд зориулсан олон чиглэлийн мониторинг болон үнэлгээний хөтөлбөр боловсруулна. Энэхүү хөтөлбөр нь одоогийн усны мониторингийн хөтөлбөр болон чухал экосистемийн үйлчилгээний мониторинг, мөн Бор Овоогийн ундаргын мониторингийн үйл ажиллагаанд суурилж, нэгтгэнэ. Уг хөтөлбөрийг байгаль орчны болон нийгмийн мэргэжилтнүүд хамтран боловсруулах ба нийгмийн мониторингийн үйл ажиллагаатай нэгтгэнэ. Экосистемийн үйлчилгээний мониторинг болон үнэлгээний хөтөлбөрт дасан зохицох удирдлагын стратегийг багтаах ба урт хугацаанд нийцлийг хангахад шаардлагатай холбогдох хэмжүүр, үзүүлэлтүүдийг багтаана.	(i) Одоогийн ургамал, бэлчээрийн чанар, экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах стратегид зөрүү шинжилгээг хийсэн  (ii) Санхүүжүүлэгчдээр мониторинг, үнэлгээний хөтөлбөрийн төслийг хянуулахаар өгсөн (хамааралтай бол тусгай төлөвлөгөө)  (iii) Мониторинг, үнэлгээний хөтөлбөрийг эцэслэж, хэрэгжүүлж эхэлсэн (хамааралтай бол тусгай төлөвлөгөө)	(i) Дууссан  (ii) 2016 оны 2 дугаар улирал  (iii) 2016 оны 4 дүгээр улирал
7	Агаараас хийх зэрлэг амьтдын судалгаа	БОЯБҮМХ-д тодорхойлсны дагуу туурайтны ажиглалтад дэмжлэг облох зорилгоор тодорхой давтамжтайгаар агаараас зэрлэг амьтдын судалгааг хийнэ.	(i) Удирдамжийг Санхүүжүүлэгчдэд танилцуулна (ii) Ажиглалт хийгдэнэ	(i) 2018 оны 4 дүгээр улирал (ii) 2019 оноос цааш БОЯБТҮМ-д тодорхойлсон давтамжийн дагуу
<b>ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ</b>				
8	Дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөр болон төлөвлөгөө	ОТ одоо байгаа ОТ Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, ОТ Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний ном болон Санхүүжүүлэгчдийн шаардлагын бичиг баримтуудад суурилсан дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт дараах зүйлсийг багтаасан Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө (ДХУТ) орно:	(i) Одоогийн дүйцүүлэн хамгаалах ажиллагааг тодорхойлж, үнэлэх ба шинэ мэдээг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ  (ii) ДХУТ-ний төслийг	(i) Дууссан  (ii) 2016 оны 1 дүгээр улирал

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

		<p>(a) дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг дэмжих дүйцэх ОТ-н сонгосон санхүүжилтийн тогтолцоо,</p> <p>(b) 2012 онд нийтэлсэн ОТ-н дүйцүүлэн хамгааллын стратегид суурилсан, ОТ-н төлөвлөлтийн хугацаанд тохирсон урт хугацааны төсвийн төлөвлөгөө (ж.нь жил бүр, 2 болон 5 жилийн төлөвлөгөө). Хөтөлбөрийн нийт зардлын тооцоог шинэчлэх ба цаашид жил бүр шинэчлэхдээ</p> <p>(c) холбогдох ЦЭН тооцоонд үндэслэнэ</p> <p>(d) Хамгаалах үйл ажиллагаагаар дамжуулан биологийн олон янз байдалд өндөр үр ашиг авчрахад хангалттай хэмжээнд төслийн үйл ажиллагаанаас нэн чухал төрөл зүйлүүдэд нөлөөлөх нөлөөг бууруулах жил бүрийн болон урт хугацааны гол хэмжүүрүүдийг тодорхойлох ба ингэснээр ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6 болон ЕСБХБ-ы Гүйцэтгэлийн шаардлага 6-д урт хугацаанд нийцэх ба мөн уурхайн ажиллах хугацаанд Цэвэр эерэг үр ашиг авчрах зорилгод хүрнэ.</p>	<p>хянуулахаар БОНХЗ болон Санхүүжүүлэгчдэд хүргэх ба дүйцүүлэн хамгаалах санхүүжилтын боломжит хувилбаруудыг багтаана</p> <p>(iii) ДХУТ-ний эцсийн төслийг хянуулахаар БОНХЗ болон Санхүүжүүлэгчдэд хүргэж, батлуулна. Эцсийн хувилбар нь ДХУТ-ний агуулгад орсон асуудлуудыг бөгөөд БОЯБУАТ, ГС6 болон ГШ6-д тусгасан шаардлагуудыг хангана</p> <p>(iv) ОТ болон Санхүүжүүлэгчид зөвшөөрсөн эцсийн ДХУТ-г олон нийтэд танилцуулна</p>	<p>(iii) 2016 оны 1 дүгээр улирал</p> <p>(iv) 2016 оны 2 дугаар улирал</p>
9	Цэвэр эерэг нөлөөллийн (NPI) тооцоолол	Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө (ДХУТ) болон менежментийн өөрчлөлтийн хүрээнд ДХУТ-г шинэчилсэн тохиолдолд холбогдох ЦЭН тооцоог шинэчилж Санхүүжүүлэгчдэд хүргэнэ.	<p>(i) 2015 оны дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагааны ЦЭН тооцоог шинэчилж, үр дүнг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ</p> <p>(ii) ДХУТ-тай холбоотойгоор ЦЭН тооцоог шинэчилнэ</p> <p>(iii) Шинэчилсэн ЦЭН тооцоог олон нийтэд танилцуулна</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) 2016 оны 1 дүгээр улирал</p> <p>(iii) 2016 оны 2 дугаар улирал болон цаашид ОТ болон Санхүүжүүлэгчид харилцан тохирсон хугацаанд</p>
10	Дүйцүүлэн хамгааллын санхүүжилт	Санхүүжүүлэгчидтэй тохиролцсоны дагуу дүйцүүлэн хамгааллын санхүүжилтын тогтолцоог (8-р зүйлд дурьдсанаар) хуулийн үүднээс баталгаажуулж, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн урт хугацааны хэрэгжилтийг хангахад шаардагдах бүх удирдлага болон захиргааны тогтолцоог бий болгосон байна.	Тогтолцоог бий болгоно	Байгаль орчны болон нийгмийн сертификатыг олгох үед, эсвэл олгохын

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

				ӨМНӨ
<b>УУРХАЙН ТАЛБАЙ ДАХЬ НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ</b>				
11	Галбын говийн Шувуудад чухал бүс (ШЧБ)-д ирээдүйд явуулах барилга болон засварын үйл ажиллагаа	ОТ компани яаралтай бөгөөд цаг хугацааны хувьд онцгой нөхцөл шаардсан засварын ажлаас бусад нөхцөлд Галбын говийн ШЧБ болон бусад эмзэг бүс нутагт Жороо тоодогийн үржлийн хугацаанд (4 сарын 15-аас 6 сарын 30) барилгын болон засварын ажил явуулахгүй.	(i) Үйл ажиллагааны шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд зайлсхийх арга хэмжээ орно  (ii) Уурхайн талбай дахь мониторингийн хүрээнд хэрэгжилтийг баталгаажуулна	(i) Дууссан  (ii) 2013 оноос хойш хэрэгжиж байгаа
12	Цахилгааны шугамын тусгаарлалт	Дунд болон/эсвэл бага хүчдэлийн цахилгаан эрчим хүчний шугамын шонгууд, төгсгөл, дэд станц болон өндөр хүчдэлийн шонгуудад тусгаарлагч суурилуулна.	(i) мэргэжлийн зөвлөх дунд/ бага хүчдэлийн тусгаарлалтын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ  (ii) мэргэжлийн зөвлөх дунд/ бага хүчдэлийн тусгаарлалтын эрсдэлийн үнэлгээг дуусгана  (iii) холбогдох хангамж/ суурилуулалтын ажлыг эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу эхлүүлсэн  (iv) холбогдох хангамж/ суурилуулалтын ажлыг эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу дуусгасан	(i) Дууссан  (ii) Дууссан  (iii) 2016 оны 3 дугаар улирал  (iv) 2016 оны 4 дүгээр улирал
13	Замын нөлөөлөл бууруулах	Төсөл гүйцэтгэгч ОУСК-ийн ГС6, ЕСБХБ-ы ГШ6 болон ОТ-н цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх үүрэг амлалтыг хэрэгжүүлэхийн тулд ОТ компани нь: (i) дараах хэсгүүд болон эдгээрээр хязгаарлагдахгүй ОТ-ГС замын нөлөөлөл бууруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ: а) замын хаалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалт, б) бүс нутгийн	(i) Стратегийн төслийг хянуулж, санал авахаар Санхүүжүүлэгчдэд өгнө	(i) 2016 оны 2 дугаар улирал  (ii) 2017 оны 1

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

		хэмжээний тогтвортой хөгжилтэй хамааралтай зарим нөлөөлөл бууруулах арга хэмжээнд оролцох бүс нутгийн байгууллагуудтай албан ёсоор хамтран ажиллах, с) ОТ-ГС зам болон ОТ-н бус замын хөдөлгөөнийг хянах, мөн амьтдад нөлөөлж буй нөлөөллийг хянах, (ii) Замын нөлөөллийг бууруулах страгийг бие даасан шинжлэх ухааны зөвлөлд хянуулахаар өгнө (iii) Зөвлөлийн хянаснаар ОТ болон Санхүүжүүлэгчдийн харилцан тохиролцсон арга хэмжээг стратегид оруулна (4 дүгээр зүйлийг харах)	(ii) Бие даасан зөвлөл стратегийг хянана  (iii) Стратегийн хэрэгжилтийг эхлүүлэх	дүгээр улирал  (iii) 2017 оны 3 дугаар улирал
14	Замаас гадуурх хөдөлгөөн	Оюу толгой компани нь:  (i) одоо явуулж буй оролцогч талуудтай хамтран ажиллахтай холбоотой мэдээлэл болон боловсрол олгох ажлын хүрээнд замаас гадуур жолоодох болон үүний улмаас өрх гэр, зэрлэг амьтдын хамгаалалд хэрхэн нөлөөлөх талаар матераил боловсруулж түгээх  (ii) замаас гадуур жолоодохтой холбоотой шаардлагуудыг гэрээт байгууллагын менежментийн хөтөлбөр болон шинэ болон гэрээт ажилчдын танилцуулах сургалтын хөтөлбөрт оруулах.	(i) Мэдээллийн материалуудыг БОНХЗ-ийн мониторингийн үйл ажиллагаанд оруулна  (ii) Замаас гадуур жолоодохтой холбоотой үр дагаврыг харуулсан материалыг үндсэн болон гэрээт ажилчдын сургалтанд оруулна	(i) 2016, аудитын хуваарийн дагуу  (ii) Дууссан
15	Биологийн олон янз байдлын сургалтын багц	ОТ компани (i) барилгын болон ашиглалтын ажилтнуудад (оператор болон гэрээт) зориулсан жолоодлогын дүрэм, хог хаягдлын журам, хууль бус ургамал, амьтны бүтээгдэхүүн зэрэг биологийн олон янз байдалтай холбоотой сэдэв бүхий сургалтын багц боловсруулна, (ii) голлох биологийн олон янз байдалтай холбоотой сэдвүүдийг өглөөний хурлын ярилцах сэдэвт оруулах (iii) одоогийн танилцуулга сургалтыг дахин хянаж, холбогдох шаардлагуудыг оруулсан болохыг бататгах.	(i) Сургалтын багцийг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ  (ii) болон (iii) арга хэмжээг хэрэгжүүлнэ	(i) Дууссан  (ii) болон (iii) хэрэгжиж буй
<b>ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ</b>				
16	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө	Оюу толгой компани нь (i) уурхайн талбай дахь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг хэрэгжүүлэх, (ii) дүйцүүлэн хамгааллын удирдлагын хөтөлбөр болон төлөвлөгөө, (iii) бүс нутгийн хэмжээний төлөвлөлттэй холбоотой хамтын ажиллагааг хамарсан зорилтот Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулна.	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө шинэчлэгдэнэ	2016 оны 2 дугаар улирал

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

17	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөртэй холбоотой оролцогч талуудтай хамтран ажиллах	Оюу толгой компанийн биологийн олон янз байдлын хөтөлбөр нь бүс нутгийн хэмжээний төлөвлөлтийн асуудлыг тусгасан, Монгол улсын голлон анхаарах хамгаалах чиглэл болон оролцогч талуудын сонирхолд нийцсэн бөгөөд урт хугацаанд техник болон бодлогын талаас тогтвортой байх нөхцөлийг хангах зорилгоор оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, харилцан зөвшилцөнө. Үүнд Монгол улсын засгийн газар, бүс нутгийн удирдлага, бусад уул уурхайн компани, төслийн нөлөөнд өртсөн ард иргэд болон сонирхогч талууд (Гурван талт зөвлөл: орон нутгийн малчид, орон нутгийн удирдлага болон ОТ)-тай хамтран ажиллах үйл явц багтана.	ОТ-н явуулж буй хамтран ажиллах үйл ажиллагааг Санхүүжүүлэгчдэд өгдөг тайланд тусгах ба (ж.нь жилийн мониторингийн тайлан, бие даасан байгаль орчны болон нийгмийн мониторингийн тайлан) уулзалтын тов болон хурлын протоколыг Санхүүжүүлэгчдэд мөн өгнө.	Жил бүрийн мониторингийн тайлан болон БОНХЗ тайланд тусгагдсан
<b>УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ЖУРМУУД</b>				
18	Нөхөн сэргээлт	Оюу толгой компани нь Газар болон Биологийн олон янз байдлын багийн оролцоотойгоор Газар хөндөлтийн хяналт болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ГХХНСТ) боловсруулах ба дараах журмуудыг багтаасан байна: (a) ШИНЭЧИЛСЭН Газар хөндөлтийн журам, (b) ШИНЭЧИЛСЭН Өнгөн хөрстэй ажиллах журам, (c) ШИНЭЧИЛСЭН техникийн нөхөн сэргээлтийн журам, (d) Биологийн нөхөн сэргээлтийн журам.  БОНХЗ нь ГХХНСТ-г Санхүүжүүлэгчдийн шаардлагад нийцсэн бөгөөд БОННУ болон БОНУТ-д тусгасан холбогдох үүрэг амлалтуудыг тусгасан болохыг шалгаж баталгаажуулна.	(i) ГХХНСТ-ний төслийг БОНХЗ-өөр хянуулж, саналыг авна  (ii) Эцсийн ГХХНСТ-г БОНХЗ-д хүргүүлэн хянуулж, санал авна. ГХХНСТ нь Санхүүжүүлэгчдийн шаардлагад нийцсэн ба бүх холбогдох үүрэг амлалтуудыг тусгасан болох баталгааг БОНХЗ-өөс Санхүүжүүлэгчдэд өгнө.	(i) Дууссан  (ii) 2016 оны нэгдүгээр улирал
19	Хууль бус зэрлэг ургамал болон амьтны гаралтай бүтээгдэхүүн	Оюу толгой компани нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус ан агнуур, эсвэл ургамал түүх ажиллагааг хянах зорилгоор дараах арга хэмжээг авна: (i) Дараах нөхцөлийг хангасан зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаарх журам боловсруулж хэрэгжүүлнэ: (a) онгоц, тээврийн хэрэгсэл, ачааны үзлэгийн давтамж болон улирал тутамд заавал хийгдэх үзлэгийн доод хязгаарыг заасан шаардлага, (b) шалгаж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх	(ia) ШИНЭЧИЛСЭН журмыг хянуулахаар БОНХЗ-д хүргүүлнэ  (ib) Журмыг эцэслэнэ  (ii) Шаардлагатай сургалтыг явуулна	(ia) Дууссан (ib) Дууссан  (ii) Явагдаж буй



Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

		<p>зорилгоор үзлэгт тавигдах баримт бүртгэлийн шаардлагыг заах,</p> <p>(с) үндсэн болон гэрээт ажилтнууд хууль бус ан амьтан, эсвэл ургамлын гаралтай бүтээгдэхүүн авч явсан тохиолдолд зохих арга хэмжээг авах замаар журмын хэрэгжилтийг хангах.</p> <p>(ii) Бүх үндсэн болон гэрээт ажилтнуудыг журмын талаарх сургалт, кэмп болон нисэх буудлын ажилтнуудыг хэрхэн хууль бус амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг таних талаар сургалтад хамруулна</p> <p>(iii) Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө болон холбогдох үйл ажиллагаагаар дамжуулан уг асуудлын тухай ойлголт, мэдлэгийг сайжруулна.</p>	<p>(iii) Оролцогч талуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ</p>	<p>(iii) 2016 оны хоёрдугаар улирал</p>
<b>ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУССАН ЗҮЙЛС</b>				
Шувуу үргээгч	<p>ОТ компани нь: (i) Хятадын хилээс Оюу толгой уурхай хүрэх өндөр хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суулгана</p> <p>(ii) Гүний хоолойгоос Оюу толгой уурхай хүрэх дунд хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулна.</p> <p>(iii) Оюу толгойн уурхайгаас Ханбогд сумын төв хүрэх дунд хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулна.</p> <p>(шувуу үргээгч гэдэгт “Bird Mark – Model BM-AG (After Glow)” загвар болон “Swan” загварын мушгиа шувуу үргээгч).</p>	<p>(ia) Өндөр хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулж эхлэх</p> <p>(ib) Өндөр хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p> <p>(iia ) Дунд хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулж эхлэх</p> <p>(iib) Дунд хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p> <p>(iii) Ханбогд сумын төв хүрэх дунд хүчдэлийн цахилгаан шугамд шувуу үргээгч суурилуулж дуусгах</p>	<p>(ia) Дууссан</p> <p>(ib) Дууссан</p> <p>(iia) Дууссан</p> <p>(iib) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p>	

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

Дамжуулах шугамын суурилуулалт	<p>Жороо тоодогийн үржлийн улирлын үеэр (4 сарын 15-аас 6 сарын 30). хамгийн бага нөлөөлөл үзүүлэх зорилгоор Галбын говийн Шувуудад чухал бүст хийгдэх шугам татах үйл ажиллагааг аль болох хурдан гүйцэтгэж, 2012 оны 4 дүгээр сард багтаахын тулд Оюу толгой компани нь боломжит бүх арга хэмжээг авна .</p> <p>Бүх арга хэмжээг авсны дараа, шугам татах ажиллагааг тодорхой тооны хязгаарласан цэгүүдийн хооронд гүйцэтгэх ба уг цэгүүдэд эхлээд тоодог байгаа эсэхийг шалгана. Ингэхдээ шугам татах ажлын үеэр жороо тоодог илрүүлэгчийг ажиллуулсан байх ба жороо тоодогийн үржлийн талбай олдсон бол ОТ компани Тоодогийн мэргэжилтэнтэй холбоо тогтоож, нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх хамгийн тохиромжтой арга хэмжээг тодорхойлно.</p>	<p>(i) Шугам татах ажиллагааг эхлүүлнэ</p> <p>(ii) ШЧБ-т шугам татах 2 багийн ажлыг эхлүүлж, ШЧБ дэхь ажлыг аль болох эрт дуусгахыг зорьж ажиллана</p> <p>(iii) Шугам татаж дуусгана</p> <p>(iv) Холбогдох удирдлагын төлөвлөгөөг шинэчилнэ</p> <p>(v) Гэрээт байгууллагын гүйцэтгэлийн талаар Санхүүжүүлэгчдэд мэдээлнэ</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p> <p>(iii) Дууссан</p> <p>(iv) Дууссан</p> <p>(v) Дууссан</p>
Малын гарам	Оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр ОТ компани нь (i) ОТ – Гашуун Сухайт чиглэлийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулах арга хэмжээ болон бусад инженерийн аргачлал ашиглан мал замаар гарах боломжийг бүрдүүлсэн гарцууд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж (ii) гарцуудыг хийж гүйцэтгэнэ.	<p>(i) Эцсийн ажлын төлөвлөгөөг Санхүүжүүлэгчдэд өгнө</p> <p>(iia) Ажлыг эхлүүлнэ</p> <p>(iib) Ажлыг дуусгана</p>	<p>(i) Дууссан</p> <p>(iia) Дууссан</p> <p>(iib) Дууссан</p>
Замын тэмдэглэгээ	ОТ компани нь ОТ - Гашуун Сухайт, ОТ-оос Ханбогд болон цооногийн талбай руу хүрэх зам дагуу амьтан мөргөх эрсдэлтэйг анхааруулсан, мөн тухайн орчинд зэрлэг амьтан явдаг болохыг сануулсан замын тэмдэг суурилуулна. Тэмдэг нь “Өрнөдийн Тээвэрлэлтийн Институт”-аас гаргасан зөвлөмжид нийцсэн байна.	Тэмдэгийг суурилуулна	Дууссан
Сайрын дагуух заг болон хайлаасан шугуй	Эдгээр чухал газруудад үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор одоо хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн чанарт үнэлгээ хийж, боломжтой нөхцөлд цэвэр алдагдалд хүрэхээс зайлсхийнэ (байгалийн орчин). Мөн тодорхойлсон нэмэлт арга хэмжээг уурхайн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө болон Дүйцүүлэн хамгааллын удирдлаганы төлөвлөгөөнд тусган оруулна.	<p>(i) ОТ-н үнэлгээний үр дүнг Санхүүжүүлэгчдэд өгнө</p> <p>(ii) ОТ-н хийсэн үнэлгээнд үндэслэн нэмэлт арга хэмжээг Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө болон Дүйцүүлэн хамгаалаллын удирдлагын төлөвлөгөөнд тусгана.</p>	<p>(i) Дууссан</p> <p>(ii) Дууссан</p>
ЦЭН Протокол болон	Оюу толгой компани нь Байгаль хамгаалах олон улсын холбооны баталсан Цэвэр эерэг нөлөөний протокол болон Хяналтын комиссын баг (ЦЭНП, ХКБ)-тай хамтран ажиллах ба баг нь Рио Тинто болон Оюу	(iia) Төсөлд зориулсан ажлын хамрах хүрээг боловсруулж,	(iia) Дууссан

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

хяналтын комисс (ii)	толгой компанийн ЦЭН авчрах зорилгын хэрэгжилтийг баталгаажуулах бие даасан үйл ажиллагааг боловсруулж, шалгаж, хэрэгжүүлнэ.	Санхүүжүүлэгчдэд хүргэнэ  (iib) ОТ-н ЦЭНП, ХКБ-г баталгаажуулах хөтөлбөр эхэлнэ	(iib) Дууссан
2012 Суурь хээрийн судалгааны хөтөлбөр – Жороо тоодог	Оюу толгой компани нь мониторингийн хөтөлбөрийнхөө хүрээнд Жороо тоодогийн хээрийн биологийн олон янз байдлын суурь судалгааг эхлүүлнэ. Суурь судалгаа нь Биологийн олон янз байдлын үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго зорилтод нийцсэн байна.	(i) Гэрээг ОУСК-д хянуулахаар өгнө (ii) Багууд ажлаа эхэлнэ	(i) Дууссан (ii) Дууссан
2012 Хээрийн суурь судалгааны хөтөлбөр – том биет туурайтнууд	Оюу толгой компани нь мониторингийн хөтөлбөрийнхөө хүрээнд том биет туурайтнуудын хээрийн биологийн олон янз байдлын суурь судалгааг эхлүүлнэ. Суурь судалгаа нь Биологийн олон янз байдлын үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго зорилтод нийцсэн байна.	(i) Газраар хийх туурайтны судалгааны гэрээг ОУСК-д хянуулахаар өгнө (ii) Багууд хөдөлж, газраар хийх судалгаа эхэлнэ	(i) Дууссан (ii) Дууссан
Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө	Оюу толгой компани нь Оюу толгойн үндсэн болон гэрээт ажилтнууд, туслан гүйцэтгэгчдийн бүх үүрэг хариуцлагыг тусгаж, уурхайн талбайд явагдах биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөг бууруулах бүх үйл ажиллагааг багтаасан бөгөөд салбарын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлагыг ашигласан Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын төлөвлөгөөг боловсруулж, Санхүүжүүлэгчдээр хянуулна. Ашиглалтын шатны биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд үйл ажиллагааны шатанд хийгдэх барилгын ажилтай холбоотой үүрэг амлалт, арга хэмжээг тусгасан байна. Хамааралтай бол биологийн олон янз байдалтай холбоотой үүрэг амлалтуудыг Тээврийн удирдлагын төлөвлөгөө, Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө, Хог хаядлын удирдлагын төлөвлөгөө болон Шилжин ирэх хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө зэрэг бусад холбогдох Удирдлагын төлөвлөгөөнд тусгана.	(i) Төлөвлөгөөний төслийг Санхүүжүүлэгчдэд хянуулахаар өгнө  (ii) Эцсийн төлөвлөгөөг санхүүжүүлэгчдэд өгнө	(i) Дууссан (ii) Дууссан
Ашиглалтын шатны Биологийн олон янз	Рио Тинтогийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний явц эцэслэсний дараа Оюу толгой компани Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын төлөвлөгөөг шинэчилнэ.	Шинэчилсэн Биологийн олон янз байдлын төлөвлөгөөг Санхүүжүүлэгчдээр хянуулахаар өгнө	Дууссан

Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0004-М	Хувилбар: 1.1

	байдлын удирдлагын төлөвлөгөө			
	Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө	БОНХЗ эсвэл Ашиглалтын шатны Биологийн олон янз байдлын төлөвлөгөөг боловсруулахад оролцоогүй биологийн олон янз байдлын түншүүдийн аль нэг нь Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (БОЯБУТ) болон Хавсралт Г (Биологийн олон янз байдлын үүрэг амлалтын бүртгэл)-г хянан шалгаж, БОННУ-д тусгасан биологийн олон янз байдлын бүх үүрэг амлалтуудыг Ашиглалтын шатны удирдлагын төлөвлөгөөнүүд, эсвэл бусад холбогдох хэрэгжүүлэлтийн бичиг баримтад тусгасан болохыг шалгаж баталгаажуулна. Хэрэв ямар нэг дутагдал илэрвэл Оюу толгой компаниас уг дутагдлыг арилгаж, холбогдох Ашиглалтын шатны удирдлагын төлөвлөгөөнүүдийг хянан шинэчилнэ. .	(i) БОЯБУТ болон Хавсралт Г-г хянуулахаар БОНХЗ-д өгнө. БОНХЗ хяналт дуусаад үр дүнг Санхүүжүүлэгчдэд хүргэнэ.  (ii) БОНХЗ-ийн хяналтын үр дүнгээс хамаарч шаардлагатай бол БОЯБУТ-д шинэчлэл хийнэ.	(i) Дууссан  (ii) Дууссан
	Байгууллагын бүтэц	ОТ компани нь нийгэм-экологийн, тэр дундаа дүйцүүлэн хамгаалахтай холбоотой үүрэг амлалтуудын хэрэгжилтийг ашиглалтын шатанд хангаж ажиллахад шаардагдах байгаль орчны болон нийгмийн мэргэжилтнүүдийг (Экосистемийн үйлчилгээний групп) томилон ажиллуулна.	Олон чиглэлийн багийг бүрдүүлж, гэрээг боловсруулан Санхүүжүүлэгчдэд өгнө.	Дууссан
	Экосистем үйлчилгээний групп	ОТ компани нь Санхүүжүүлэгчдийн хамааралтай шаардлагын дагуу экосистемийн үйлчилгээний удирдлага, мөн БОЯБУАТ-д тусгасан үүрэг амлалтуудын хэрэгжилтийг Экосистемийн үйлчилгээний группт хариуцуулан томилно. Уг Групп нь экосистемийн үйлчилгээний асуудлаар Санхүүжүүлэгчдийн харилцах гол нэгж байна. Групп нь олон улсын биологийн олон янз байдлын байгууллагууд (2 дугаар зүйлд тодорхойлсны дагуу) болон экосистемийн үйлчилгээний талаар шилдэг туршлагыг хэрэгжүүлж буй бусад мэргэжилтнүүдээс дэмжлэг авч ажиллана.	Группийг нэр дэвшүүлж, Санхүүжүүлэгчдэд мэдээлсэн.	Дууссан
	Эрх зүйн хэрэгжилтийн менежмент	ОТ компани нь БОЯБУАТ, Ургамал болон Амьтны удирдлагын төлөвлөгөө, биологийн олон янз байдалтай холбоотой БОННУ-ний шаардлагуудыг ЭМААБО-ы удирдлагын тогтолцоо болон баталгаажуулалтын үйл ажиллагаандаа нэгтгэн оруулна.	Биологийн олон янз байдалтай холбоотой үүрэг амлалтуудыг ЭМААБО-ы удирдлага болон баталгаажуулалтын үйл ажиллагаандаа нэгтгэн оруулна.	Дууссан